

АГУУЛГА

I. ТӨСЛИЙН ТОВЧ ТАНИЛЦУУЛГА	3
I.1 Төслийн талаарх мэдээлэл	3
I.2 Уурхайн ажиллах горим.....	4
I.3 Хүдэр баяжуулах үйлдвэр	6
I.3.1 Исэлдсэн зэсийн хүдрийн нуруулдан уусгалт болон шимт уусмал боловсруулалт	6
I.3.2 Хүдрийг баяжуулалтад бэлтгэх	6
I.3.3 Хүдэр бутлалт.....	6
I.3.4 Бутлах хэсгийн технологийн схемийн сонголт, тооцоо.....	7
I.3.5 Бутлан ангилах төхөөрөмжийн тооцоо, сонголт	7
I.4 Хүдэр нуруулдан уусгалт.....	8
I.4.1 Нуруулдан уусгах байгууламжийн талбайн сонголт.....	8
I.4.2 Нуруулдан уусгах талбайн суурь бэлтгэл.....	10
I.4.3 Уусмал түгээх цуглуулах систем	10
I.4.4 Шүүрэлт хянах систем	10
I.4.5 Уусмал саармагжуулах үйл ажиллагаа.....	10
I.4.6 Нуруулдан уусгах үйлдвэрийн технологийн үзүүлэлтүүд, үр дүн	11
I.5 Уусмалын сангууд	12
II. БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ.....	14
II.1 СӨРӨГ НӨЛӨӨЛЛИЙГ БУУРУУЛАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨ	15
II.2 ОСОЛ ЭРСДЭЛИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ	20
II.3 ХОГ ХАЯГДЛЫН МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ	22
II.4 ТЭР БУМ МОД, ҮНДЭСНИЙ ХӨТӨЛБӨР	23
II.5 ТҮҮХ, СОЁЛЫН ӨВИЙГ ХАМГААЛАХ ТӨЛӨВЛӨГӨӨ	23
II.6 ОРЧНЫ ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭНИЙ ХӨТӨЛБӨР	24
II.7 Төслийн талбайн мониторингийн ажлууд.....	28
II.8 ТУХАЙН ЖИЛИЙН БОМТ ХЭРЭГЖҮҮЛЭХ УДИРДЛАГА ЗОХИОН БАЙГУУЛАЛТ	30

ХҮСНЭГТИЙН ЖАГСААЛ

Хүснэгт №. 1 Талбайн газар зүйн солбицол.....	4
Хүснэгт №. 2 Уурхайн ажиллах горим	4
Хүснэгт №. 3 Хүдрийн нуруулдан уусгалт болон шимт уусмал боловсруулалтын үзүүлэлт	6
Хүснэгт №. 4 Нуруулдан уусгах талбайн үндсэн хэмжээснүүд	9
Хүснэгт №. 5 Зэсийн баланс.....	11
Хүснэгт №. 6 Усны баланс.....	11
Хүснэгт №. 7 Б.Ү-ийн хүдэр нийлүүлэлтийн төлөвлөгөө	11
Хүснэгт №. 8 Бүтээгдэхүүн гаралт	11
Хүснэгт №. 9 БОМТ-ийн нийт зардал	14
Хүснэгт №. 10 Сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөө.....	15
Хүснэгт №. 11 Осол эрсдэлийн төлөвлөгөө	20
Хүснэгт №. 12 Хог хаягдлын менежментийн төлөвлөгөө	22
Хүснэгт №. 13 Төслийн талбайн ойжуулалтын зардал	23
Хүснэгт №. 14 Орчны шинжилгээний хөтөлбөр	26
Хүснэгт №. 15 Мониторингийн цэгийн солбицол	28
Хүснэгт №. 16 Тухайн жилийн БОМТ хэрэгжүүлэх удирдлага зохион байгуулалтын зардал.....	30
Хүснэгт №. 17 БОМТ-г тайлагнах хуваарь	31


ЗУРГИЙН ЖАГСААЛТ

Зураг №. 1 Төслийн талбайн байршил.....	3
Зураг №. 2 Тусгай зөвшөөрлийн талбайн сансарын зураг.....	3
Зураг №. 3 Уурхайн хотхон.....	4
Зураг №. 4 Баяжуулах үйлдвэр.....	5
Зураг №. 5 Уусмалын талбай болон нуруулдан уусгах талбай	5
Зураг №. 6 Хүдрийн овоолго, машин механизм.....	5
Зураг №. 7 Нуруулдан уусгах байгууламжийн талбайн байршил.....	9
Зураг №. 8 Нуруулдан уусгах байгууламжийн зүсэлт.....	9
Зураг №. 9 Мониторингийн цэгүүд	28


I. ТӨСЛИЙН ТОВЧ ТАНИЛЦУУЛГА

I.1 Төслийн талаарх мэдээлэл

Төслийн байршил: Тусгай зөвшөөрлийн талбай нь засаг захиргааны хувьд Баян-Өлгий аймгийн Дэлүүн сумын нутагт харьяалагдах ба Улаанбаатар хотоос баруун зүгт 1950 км-т, Баян-Өлгий аймгийн төвөөс урагш 207 км-т, Дэлүүн сумаас баруун урагш 31 км-т оршино. Тус талбай нь томоохон сууринаас алслагдсан дэд бүтэц муу хөгжсөн бүсэд хамаарагдах ба орон нутгийн сайжруулсан шороон авто замаар холбогдсон байдаг.



Зураг №. 1 Төслийн талбайн байршил



Зураг №. 2 Тусгай зөвшөөрлийн талбайн сансарын зураг

Хүснэгт №. 1 Талбайн газар зүйн солбицол

Талбайн булангийн цэгүүд	Өргөрөг	Уртраг
1	47° 29' 21.5"	90° 45' 59.17"
2	47° 29' 21.5"	90° 43' 59.17"
3	47° 32' 1.54"	90° 43' 59.07"
4	47° 32' 1.54"	90° 45' 59.54"

Төсөл хэрэгжүүлэгч: “Орчлон – Орд ” ХХК нь Монгол улсын 9011110084 тоот бүртгэлийн дугаар бүхий аж ахуйн нэгжийн гэрчилгээтэй.

Төсөл хэрэгжүүлэгчийн хаяг: Улаанбаатар хот, Баянгол дүүрэг, 19-р хороо, Жалханц хутагт Дамдинбазар, 63, 3 тоот, Утас1: 99021388, Утас2: 90351200

1.2 Уурхайн ажиллах горим

Уурхайн үйл ажиллагаа нь жилийн турш тасралтгүй 337 хоног ажиллана. 28 хоног нь төлөвлөгөөт бус сул зогсолт байна. Уурхай нь хоногт 2 ээлжээр, ээлжийн үргэлжлэх хугацаа 12 цагаар ажиллана.

Хүснэгт №. 2 Уурхайн ажиллах горим


№	Үзүүлэлт	Хэмжих нэгж	Хэмжээс	Тайлбар
1	Жилийн ажлын горим	Тасралтгүй		
2	Жилийн календарь хугацаа	хоног	365	
3	Жилд ногдох ажлын бус хоног	хоног	28	Цаг агаарын саатал, төлөвлөгөөт бус сул зогсолт
4	Жилд ажиллах хоног	хоног	337	
5	Хоногийн ажлын горим		2 ээлжээр	
6	Ээлжийн хугацаа	цаг	12	
7	Хоногт ногдох ажлын нийт цаг	цаг	24	
8	Жилд ногдох ажлын нийт цаг	цаг	8400	



Зураг №. 3 Уурхайн хотхон



Зураг №. 4 Баяжуулах үйлдвэр



Зураг №. 5 Уусмалын талбай болон нуруулдан уусгах талбай



Зураг №. 6 Хүдрийн овоолго, машин механизм

I.3 Хүдэр баяжуулах үйлдвэр

I.3.1 Исэлдсэн зэсийн хүдрийн нуруулдан уусгалт болон шимт уусмал боловсруулалт

Тус ордын ашиглалтын 11 жилийн хугацаанд 6.7 сая.тн исэлдсэн зэсийн хүдрийг нуруулдан уусгана. Нуруулдан уусгах байгууламж нь 20.0 м өндөртэй 6.7 сая.тн хүдэр нуруулдан уусгана. Тус компани нь 0,48-0.50 %-ийн агуулгатай исэлдсэн зэсийн хүдрийг нуруулдан уусгалтын технологиор баяжуулж, боловсруулах үйлдвэр нь 22.85 мян.тн цементацийн зэс үйлдвэрлэнэ.

Хүснэгт №. 3 Хүдрийн нуруулдан уусгалт болон шимт уусмал боловсруулалтын үзүүлэлт

Нуруулдан уусгах талбайн хүчин чадал	700,000.0	тн/жил
	58,333.33	тн/сар
	1,944.44	тн/өдөр
	81.02	тн/цаг
Цементацийн үйлдвэрийн хүчин чадал	11	жил
	2,285.0	тн/жил
	190.4	тн/сар
	6.33	тн/өдөр
	0.26	тн/цаг
Хүдэр бэлтгэх технологи	2 шатны бутлалт, 1 шатны шигшилт	
Нуруулдах хүдрийн ширхэглэлийн хэмжээ		-12мм
Нуруулдан уусгалтын ерөнхий металл авалт		70%
Цементацийн металл авалт		90.0%
Нийт металл авалт		63.0 %

I.3.2 Хүдрийг баяжуулалтад бэлтгэх


Баяжуулах үйлдвэрийн зэсийн хүдэр баяжуулахад бэлтгэх хэсэг нь: Хүдэр хүлээн авах, хүдэр бутлах гэсэн 2 үндсэн хэсгээс бүрдэнэ.

Ил уурхайгаас ирэх 350 мм-ийн хүдрийг 2 шатны бутлалт хяналтын нэг шатны шигшилттэй схемээр ширхэглэлийн хэмжээг -12 мм хүртэл бутална. Овор хэтэрсэн +350 мм-ийн чулуулгийг механик аргаар бутална.

I.3.3 Хүдэр бутлалт

Хүлээн авах бункерын дээд хэсэгт хөдөлгөөнгүй байрлуулсан 350 мм-ийн хэмжээтэй сараалжин гулдмайт шигшүүрээр хүдэр нь шигшигдэнэ. Овор хэтэрсэн хүдрийг урьдчилан буталж жижиглэсэн байх шаардлагатай. Шигшигдсэн 350мм-ийн ширхэгтэй хүдэр нь GZD загварын чичиргээт тэжээгүүр жигд хуваарилагдан PE 600*900 маркийн хацарт бутлуурт (том бутлал) 75.0 мм болтол бутлагдана. Том бутлалтаас гарсан -75мм ширхэглэлтэй хүдэр туузан конвейероор хоёрдугаар шатны PYY900/75 маркийн конусан бутлуурыг тэжээнэ. Конвейерын дунд хэсэгт бутлуурт хатуу биет орохоос сэргийлж металл баригч байрлуулна. Бутлуурын ашигт ажиллагааг хэвийн хангах үүднээс 2-р шатны буталгааны өмнө 2YK2160 маркийн чичиргээт шигшүүр суурилуулна. 2-р шатны PYY900/75 маркийн конусан бутлуураас гарсан -12.0мм ширхэглэлтэй хүдрийг нуруулдан уусгалтын хэсэг үрүү зөөвөрлөнө.

1.3.4 Бутлах хэсгийн технологийн схемийн сонголт, тооцоо



Бутлагдсан хүдэр (-12 мм)

Зураг № 1. Хүдэр бутлах технологийн схем

Баяжуулах үйлдвэрийн бутлах хэсгийн цагийн бүтээл:

$$Q_0 = \frac{Q_{ж}}{Q_{а.х} \cdot t_a \cdot K_B \cdot K_H} = \frac{700000}{365 \cdot 24 \cdot 0.85 \cdot 0.95} = 98.96 \approx 99.0 \text{ т/цаг}$$

Энд: $Q_{ж}$ - жилд боловсруулах хүдрийн хэмжээ, т/жил

$Q_{а.х}$ - жилд ажиллах хоног

t_a - хоногт ажиллах нийт цаг, цаг

K_B – цаг ашиглалтын коэффициент – 0.95 (“Баяжуулах үйлдвэрийн төсөл зохиомж” 2007 он); K_H – тоног төхөөрөмжийн бэлэн байдлын коэффициент - 0.85.

1.3.5 Бутлан ангилах төхөөрөмжийн тооцоо, сонголт

1. Бутлалтын ерөнхий зэргийг олбол:

$$S_{ep} = \frac{D_{max}}{d_{max}} = \frac{350}{15} = 23.3$$

энд: D_{max} – анхдагч хүдрийн хамгийн том мөхлөгийн хэмжээ, мм;

d_{max} – бутлагдсан хүдрийн хамгийн том мөхлөгийн хэмжээ, мм.

2. Шат тус бүрийн бутлалтын зэргийг тодорхойлбол:

$$S_{дун} = \sqrt{S_{ep}} = \sqrt{23.3} = 4.83$$

$$S_{дун} > S_1 ; S_{дун} < S_2$$

$$S_1 = 4.7 ; S_2 = 6.2$$

3. Шат тус бүрийн бутлагдсан бүтээгдэхүүний хамгийн том хэмжээг тодорхойлбол:

$$D_1 = \frac{D_{max}}{S_1} = \frac{350}{4.7} = 75.0 \text{ мм}$$

$$D_2 = \frac{D_1}{S_2} = \frac{75}{6.2} = 12 \text{ мм}$$

4. Шат тус бүрийн бутлалтын бутлуурын гаргах завсрын өргөн:

Бутлалтын нэг, хоёрдугаар шатанд хацарт бутлуурыг суурилуулна.

$$i_1 = \frac{D_1}{Z_{II}} = \frac{75}{1.5} = 50.0\text{мм} \qquad i_2 = \frac{D_2}{Z_I} = \frac{12}{1.5} = 8.0\text{мм}$$

энд: Z_I, Z_{II} – бутлагдсан хүдрийн хамгийн том болзолт ширхэглэлийн хэмжээ.

5. Бутлалтын бүтээмжийг тодорхойлбол:

$$Q_1 = Q_2 = Q_4 = 98.96 \text{ тн/цаг}$$

6. Шигшилтийн мөчлөгийн бүтээмжийг тодорхойлбол:

$$Q_{4'} = Q_2 \cdot \beta_2^{-a} \cdot E_2^{-a} = 98.96 \cdot 0.7 \cdot 0.85 = 59.2, \text{ тн/цаг}$$

энд: Q_2 – бутлах төхөөрөмжийн тооцооны бүтээмж, тн/цаг;

a – торны нүхний хэмжээ, 10мм;

β_1^{-a} – (- a) ангиллын агуулга, нэгж хувь;

E_1^{-a} – (- a) ангиллын шигшилтийн үр ашиг, %;

Шигшүүрийн торны дээрх бүтээмж нь, тн/цаг:

$$Q_5 = Q_6 = Q_2 - Q_4 = 98.96 - 59.2 = 39.76 \text{ тн/ц}$$

Бутлалтын 2-р шатанд суурилуулах хацарт бутлуурын шаардагдах хүчин чадал: Эргэлтийн ачаалал $C = 1.3\%$, S - нэг цагт эргэлтэнд орох бүтээгдэхүүний масс, т/цаг

$$S = Q_5 \cdot C = 39.76 \cdot 1.3 = 51.69 \approx 52.0 \text{ т/ц}$$

Цагт урьдчилсан болон хяналтын шигшилтэнд орох хүдрийн хэмжээ:

$$Q_3 = Q_1 + S = Q_2 + Q_6 = 98.96 + 51.69 = 150.6, \text{ тн/цаг}$$


Бутлах хэсгийн I ба II, шатны бутлалтанд сонгох бутлуурын технологийн шаардлагын дагуу / хүснэг 11 / бутлалтын I шатанд цагт 56-192 тонн хүдэр бутлах хүчин чадалтай PE 600*900 маркийн хацарт бутлуур, II шатанд цагт 17.0-55.0 тонн хүдэр бутлах хүчин чадалтай PYY900/75 маркийн конусан бутлууруудыг суурилуулахаар тус тус сонголоо.

I.4 Хүдэр нуруулдан уусгалт

Нуруулдан уусгалт нь уусгалт явуулах байгууламж, уусмал цуглуулах шугам сан, уусмал шахах насос станцуудаас бүрдэнэ. Уусгалтын ажил нь жилийн дөрвөн улиралд тасралтгүй явагдана. Хүдрийн эзлэхүүн жин 1.96 тн/м^3 байна.

I.4.1 Нуруулдан уусгах байгууламжийн талбайн сонголт


Нуруулдан уусгах талбай нь уусмал өөрийн урсгалаар чөлөөтэй урсах, доошоо нэвчих эрсдэл зэргийг үндэслэн сонголтыг хийнэ. Нуруулдан уусгах байгууламж нь 6.7 сая.тн хүдрийг 20.0 м өндөр нуруулдана.



Зураг №. 7 Нуруулдан уусгах байгууламжийн талбайн байршил

Хүснэгт №. 4 Нуруулдан уусгах талбайн үндсэн хэмжээснүүд

№	Үзүүлэлт	Хэмжих нэгж	Нуруулдан уусгах байгууламж-1
1	Талбайн суурийн хэмжээ	м ²	117.18
2	Талбайн суурийн хэмжээ	га	17.71
3	Суурийн урт	м	487.0
4	Суурийн өргөн	м	383.0



Зураг №. 8 Нуруулдан уусгах байгууламжийн зүсэлт

Нуруулдан уусгах байгууламжид нуруулдсан хүдрийг зуны улиралд бороожуулах систем ашиглан хүхрийн хүчлийн сулруулсан уусмалаар 240 м³/цаг хүчин чадалтайгаар Dn=400 мм-ийн параллель HDPE хоолойгоор 1.5 мПа хүртэл даралттайгаар шахаж хүдрийг уусгана. Шимт уусмалыг 400 мм HDPE CPE хоолойгоор цуглуулан тунгаах санд тэжээнэ.

I.4.2 Нуруулдан уусгах талбайн суурь бэлтгэл

Суурийн талбайг тэгшилж MNS ASTM D1557 стандарт туршилтын 95 %-иас багагүй хэмжээнд хүртэл нягтруулж бэлтгэнэ. Овоолгын талбай, уусмалын сангуудын байгуулахдаа тэдгээрийн суурийн дизайныг ижил хийсэн байна. Тухайлбал суурийн ёроолд 30 см зузаан шаврын үе, дээр нь 300 гр/см² ачаалал даах чадвартай 1.0 мм зузаантай геотекстил буюу зулхай, дээр нь 2 мм HDPE геомембран буюу полиэтилен хулдаас дэвсэж өгсөн байна. Олон давхар үе давхарга үүсгэх үндсэн шалтгаан нь уусмал доошоо алдагдах, байгальд орчин сөрөг нөлөө үзүүлэхээс сэргийлэх сайн талтай гэж

I.4.3 Уусмал түгээх цуглуулах систем

Нуруулдсан хүдрийг уусмалаар уусгахын тулд зуны улиралд бороожуулагч (wobbler), өвлийн улиралд дусаагуурыг (dripper) ашиглан уусгана. Нуруулдсан хүдрийн уусгалтыг хэвийн нөхцөлөөр явуулахын тулд тусгайлан бэлдсэн овоолго дээр уусмал түгээх шугам хоолойг байрлуулж түүнээс бороожуулагчийн хоолойгоор уусмалыг уусгалтын нийт талбайд жигд түгээнэ.

Насос станцаас 400 мм-ийн диаметртэй HDPE хоолойгоор уусмалыг нуруулдсан хүдэрт дамжуулах ба түүнээс 250 мм-ийн диаметртэй HDPE хоолойнуудыг холбоно. 250 мм-ийн хоолойгоос 110 мм, 63 мм, 16 мм-ийн нарийн хоолойнуудаар салбарлуулан шүршигч системээр хүдэрт уусмалыг өгнө.

Өвлийн улиралд уусгалтын дусаал гаргах системээр явуулна. Дусаагуурын хоолойг 30-50 см -ийн хүдрийн доор 20 см торлолоор тавина. 1 дусаагуурын нүх нь 20 см диаметртэй талбайг нэвчүүлж байхаар тооцно. Нуруулдан уусгах байгууламжийн сууринд уусмал цуглуулах (загасан нуруу хэлбэртэй) хоолойг угсарна.

I.4.4 Шүүрэлт хянах систем

Нуруулдан уусгах байгууламж болон уусмалын сангуудаас газрын гүнд химийн хорт хаягдал нэвчихээс сэргийлэн байгууламжуудын суурийг нягтруулж бэлдэх, шавар үе дэвсэх, хамгаалалтын хайрга дэвсэх зэрэг ажлуудыг гүйцэтгэнэ.

Нуруулдан уусгах байгууламжийн хянах системийг уусмал цуглуулах сувагтай холбоно. Хяналтын цооногийн хоолой нь DN110 мм-ийн хэмжээтэй HDPE хоолой байна. Хяналтын цооногуудыг нуруулдан уусгах байгууламжийн уусмал цуглуулах сувагт ил гаргах ба түүгээр уусмал нэвчилт явагдаж буй эсэхийг шалгана. Шугамыг 100 м-ийн зайтайгаар байрлуулна. Шимт уусмалын сан, Цементацийн тэжээлийн сан, Ядуу уусмалын сан, Аваарын сан зэрэгт хяналтын цооногуудыг суурилуулна.

I.4.5 Уусмал саармагжуулах үйл ажиллагаа

Ашиглалтын хугацаа дуусаж үйлдвэрийн сангуудыг хаах үеэс эхлэн ядуу уусмалын санд хүчил нэмэхгүйгээр усаар нуруулдан уусгах байгууламжуудыг саармагжуулах үйл ажиллагаа эхэлнэ. Нуруулдсан хүдрээс шүүрэн гарах уусмалын орчныг pH=8 -ийн түвшинд хүргэнэ. Нуруулдсан хүдрээс үйлдвэрлэлийн зэсийн агуулгатай уусмал бууж ирсэн тохиолдолд үйлдвэрлэлд оруулж ашиглана. Шүүрэлт илрүүлэх цооногуудаас тогтмол дээж авч хяналтын ажлыг давхар гүйцэтгэнэ.

Хаягдал усыг MNS 4943:2011, MNS 3597:1983, MNS 6148:2010 зэрэг стандартуудын шаардлагад хүртэл нуруулдан уусгах байгууламжид овоолсон хүдрийг усаар саармагжуулах ба энэхүү үйл ажиллагаа 2-3 жилийн хугацаанд явагдана.

I.4.6 Нуруулдан уусгах үйлдвэрийн технологийн үзүүлэлтүүд, үр дүн Металлын баланс

Металлын балансыг тооцохдоо уусмалын дундаж урсгалд үндэслэн тооцсон . Нуруулдан уусгах байгууламжаас цагт 1.6 гр/м³ зэсийн дундаж агуулгатай 240.00 м³ уусмал орж ирэхээр тооцсон.

Хүснэгт №. 5 Зэсийн баланс

Нуруулдан уусгалт					
№	Үзүүлэлт	Урсгал, м ³ /цаг	Зэс, гр/л	кг/ц	тн/өдөр
1	Нуруулдсан хүдэр	240.00	1.6	352.8	8.33
2	Ядуу уусмал	240.00	0.16	31.2	0.749
3	Ууршилт	10.0	-	-	-
4	Нэмэлт ус	10.0	-	-	-
	Нийт	240.00	1.60	384.00	9.08
5	Шимт уусмал	240.00	1.60	384.00	9.08
	Нийт	240.00	1.60	384.00	9.08

Усны баланс: Усны балансыг тооцохдоо ордын цаг уурын байдал, үйлдвэрлэлийн усны алдагдал зэргийг тооцсон.

Хүснэгт №. 6 Усны баланс

Нуруулдан уусгалт			
№	Үзүүлэлт	Урсгал, м ³ /цаг	м ³ /хон
1	Нуруулдсан хүдэр	240.00	5760.0
2	Ядуу уусмал	240.00	5760.0
3	Алдагдал	10.0	240.0
4	Нэмэлт ус	10.0	240.0
	Нийт	240.00	5760.0
5	Шимт уусмал	240.00	5760.0
	Нийт	240.00	5760.0
№	Зэрэгцээ хандлалт		

Хүснэгт №. 7 Б.Ү-ийн хүдэр нийлүүлэлтийн төлөвлөгөө

Ашиглалтын жил	Зэсийн хүдрийн үйлдвэрлэлийн нөөц, мян.тн	
	Хүдрийн хэмжээ, мян.тн	Дундаж агуулга, %
Эхний жил	590.10	0.5
2 дахь	648.26	0.5
3 дахь	619.25	0.5
4 дэх	600.50	0.5
5 дахь	623.3	0.5
6 – 8 дахь	2031.30	0.49
9-11-р жил	1550.00	0.48
Нийт	6662.71	0.49

Хүснэгт №. 8 Бүтээгдэхүүн гаралт

№	Үзүүлэлт	Хэмжих нэгж	Ашиглалтын жилүүд							Нийт
			1 -р жил	2 -р жил	3 -р жил	4 -р жил	5 -р жил	6 -8 жил	9 -11 жил	
1	Уусгалтад орох хүдэр	мян.тн	590.10	648.26	619.25	600.50	623.30	2031.30	1550.00	6662.71
2	Уусгалтад орох хүдрийн агуулга	%	0.50	0.50	0.50	0.50	0.50	0.49	0.48	0.49
3	Уусгалтад орох зэс	мян.тн	2.95	3.24	3.10	3.00	3.12	9.95	7.44	32.65

4	Хүхрийн хүчил	мян.тн	14.7 5	16.2 1	15.4 8	15.0 1	15.5 8	50.7 8	35.75	163. 56
5	Дундаж металл авалт	%	70.0 0	70.0 0	70.0 0	70.0 0	70.0 0	70.0 0	70.00	70.0 0
6	Үйлдвэрлэх бүтээгдэхүүн	мян.тн	2.07	2.27	2.17	2.10	2.18	6.97	5.21	22.8 5
7	Уусмал дахь зэсийн агуулга	г/л	1.6	1.6	1.6	1.6	1.6	1.6	1.6	1.6
8	Цементацийн металл авалт	%	90.0	90.0	90.0	90.0	90.0	90.0	90.0	90.0
9	Зэсийн баяжмалын агуулга	%	85.0	85.0	85.0	85.0	85.0	85.0	85.0	85.0
10	Цементацийн зэс	мян.тн	1.86	2.04	1.95	1.89	1.96	6.27	4.69	20.6 6
11	Урвалжид орох төмөр	мян.тн	4.2	4.2	4.2	4.2	4.2	12.6	12.6	46.2
12	Төмрийн тунадасны агуулга	%	1.6	1.6	1.6	1.6	1.6	1.6	1.6	1.6
13	Төмрийн тунадас	мян.тн	17.6	17.6	17.6	17.6	17.6	52.8	52.8	193. 6

Уурхайн ашиглалтын 11 жилийн хугацаанд нуруулдан уусгах байгууламжид 0.49%-ийн дундаж агуулгатай **6.7** сая.тн хүдэр нуруулдан овоолохоор төлөвлөсөн ба 70%-ийн дундаж металл авалттайгаар **22.853** мян.тн цементацийн зэс үйлдвэрлэн борлуулахаар тооцооллоо. Урвалжид 46.2 мян.тн төмөр орж 193.6 мян.тн төмрийн тунадас үүснэ.

1.5 Уусмалын сангууд

Шимт уусмал болон аваарын сангууд уусмал болон аваарын сангууд нь нуруулдан уусгах байгууламжаас ирэх болон овоолгод өгөх уусмал, хур тунадасны ус болон тоног төхөөрөмжийн аваарын үед алдаж болох уусмалыг хадгалах зориулалттай байна.

Үндсэн 5 төрлийн сан байх ба тунгаах, шимт уусмал, үйлдвэр тэжээх, ядуу уусмалын аваарын сангууд байна.

- Тунгаах сан - 1000 м³
- Шимт уусмалын сан – 7200 м³
- Үйлдвэрийн тэжээлийн сан – 1835 м³
- Ядуу уусмалын сан – 200 м³
- Аваарын сан – 2550 м³

Сангууд нь нуруулдан уусгах байгууламжийн урд байрлана. Гидрометаллургийн үйлдвэр нь цагт 220 -300 м³ шимт уусмал өөрийн урсгалаар дамжих бөгөөд хэрэв хандлалт, цахилгаан химийн үйлдвэр 1 хоног ажиллахгүй зогсвол 5760 м³ цугларах боломжтой.

Сангуудын эзлэхүүнийг тооцоходоо 100 жилд давтагдах хур тунадасны хэмжээ, үйлдвэрлэлийн үйл ажиллагаа 12 цаг тасалдах нөхцөл болон хүчил агуулсан уусмал байгальд алдагдах эрсдэл зэргийг тооцсон.

Төслийн талбайд 100 жилд давтагдах хур тунадасны интервал 128 мм, нуруулдан уусгах байгууламж, цөөрмүүдийн талбайн хэмжээ, цагт өгөх уусмалын хэмжээ 240 м³ байхаар тооцоолол хийсэн. Дээрх хүчин зүйлсийг тооцоход 9.0 мян.

м³ уусмал багтаах эзлэхүүн шаардлагатай. Үйлдвэрийн талбайн сангуудын нийлбэр эзлэхүүн 15.80 мян. м³ байна.

Шимт уусмалын элс тунгаагуурын цөөрмөөс цементацийн цехийн тэжээлийн сан руу 1.6 гр/л зэсийн агуулгатай уусмал татна. Чанарын шаардлага хангаагүй шимт уусмалыг нуруулдсан хүдэрт буцаах зорилгоор богино эргэлтийн нэмэлт насос суурилуулна.

Уусмалын сангуудын байгуулахдаа тэдгээрийн суурийн дизайныг ижил хийсэн байна. Тухайлбал суурийн ёроолд 30 см зузаан шаврын үе, дээр нь 300 гр/см² ачаалал даах чадвартай 1.0 мм зузаантай геотекстил буюу зулхай, дээр нь 2 мм HDPE геомембран буюу полиэтилен хулдаас дэвсэж өгсөн байна. Олон давхар үе давхарга үүсгэх үндсэн шалтгаан нь уусмал доошоо алдагдах, байгальд орчин сөрөг нөлөө үзүүлэхээс сэргийлэх сайн талтай байна.

II.

II. БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ

Байгаль орчныг хамгаалах төлөвлөгөө (БОХТ)-г Монгол Улсын байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай хууль, БОАЖ-ын сайдын 2019 оны 10 дугаар сарын 29-ний өдрийн А/618 тоот тушаалын 1 дүгээр хавсралтын дагуу боловсруулав.

Байгаль орчны менежментийн төлөвлөгөө нь төсөл хэрэгжих нутаг дэвсгэрийн байгаль орчныг хамгаалах, зүй зохистой ашиглах, нөхөн сэргээх, нөлөөллийн нарийвчилсан үнэлгээгээр тогтоосон сөрөг нөлөөллийг бууруулах, арилгах, урьдчилан сэргийлэх, төсөл хэрэгжих орчинд бий болсон болзошгүй сөрөг үр дагаврыг хянах, илрүүлэх үндсэн зорилго бүхий эрхзүйн бичиг баримт юм.

“Орчлон-Орд” ХХК-ийн Баян-Өлгий аймгийн Дэлүүн сумын нутагт орших “Оюут толгой” нэртэй зэс алтны ордыг ил аргаар ашиглах төслийн үйл ажиллагаанаас байгаль орчинд үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах болон арилгахад чиглэсэн арга хэмжээнүүдийг төлөвлөх, түүнд зарцуулагдах зардлыг бодитой төлөвлөх, байгаль орчны мониторинг хийхэд энэхүү байгаль орчны менежментийн төлөвлөгөөний гол зорилго оршино.

“Оюут толгой ” нэртэй зэс алтны ордыг 11 жил ашиглахаар ТЭЗҮ-д тусгасан ба байгаль орчны менежментийн төлөвлөгөөг эхний 5 жилээр боловсрууллаа.

Хүснэгт №. 9 БОМТ-ийн нийт зардал

д/д	Ажлын нэр	1-р жил	2-р жил	3-р жил	4-р жил	5-р жил	Нийт зардал мян.төг
1	Сөрөг нөлөөлийг бууруулах	2050.0	2050.0	2050.0	2050.0	2050.0	100250.0
2	Осол эрсдлийн менежментийн төлөвлөгөө	6500.0	6500.0	6500.0	6500.0	6500.0	32500.0
3	Хог хаягдлын менежментийн төлөвлөгөө	1900.0	1900.0	1900.0	1900.0	1900.0	9500.0
4	Тэрбум мод	11000.0	11000.0	11000.0	11000.0	11000.0	55000.0
5	ОХШХ-ийн зардал	5720.0	5720.0	5720.0	5720.0	5720.0	28600.0
		27170.0	27170.0	27170.0	27170.0	27170.0	135850.0

II.1 СӨРӨГ НӨЛӨӨЛЛИЙГ БУУРУУЛАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨ

Байгаль орчны нөлөөллийн нарийвчилсан үнэлгээний явцад тогтоогдсон төслийн гол болон болзошгүй сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээ, түүнээс урьдчилан сэргийлэх, үр дагаврыг арилгах арга хэмжээ, тэдгээрийг хэрэгжүүлэх хугацаа, зарцуулах төсөв, баримтлах эрх зүйн баримт бичиг зэргийг тодорхойлон нэгтгэж тусгав.

Хүснэгт №. 10 Сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөө

№	Гол ба болзошгүй сөрөг нөлөө	Урьдчилан сэргийлэх, бууруулах, арилгах арга хэмжээ	Цар хүрээ, хэмжээ	Нэгжийн өртөг (мян.төг)	Нийт зардал (мян.төг)	Хугацаа ба давтамж	Баримтлах стандарт, аргачлал
Агаар орчин							
1	Уурхайн олборлолт болон тээврийн хэрэгслүүдийн үйл ажиллагааны улмаас гарч болох тоосжилтын эх үүсвэрүүд: Уурхайн олборлолтын үеийн хөрс хуулалт, олборлолт, бутлалт овоолго зэрэг газар шорооны ажил Ажилчдын суурин болон уурхайн олборлолтын үеийн газар шорооны ажил Уурхайн үйл ажиллагаанд буй	Төсөлд хэрэглэгдэж буй тээврийн хэрэгслүүдэд Монгол Улсад мөрдөгдөж буй утааны ба бохирдлын стандартууд (MNS 5013:2003 бензин хөдөлгүүрээс ялгарах бохирдуулагчид, MNS 5014:2003 дизель хөдөлгүүрээс ялгарах бохирдуулагчид) болон олон улсын холбогдох стандартуудын шаардлагын дагуу хяналт хийж түүнд нийцүүлнэ.	Төсөлд ашиглагдах 9 техник тоног төхөөрөмжид	1750.0	8750.0	Олборлолтод гарахын өмнө	-Агаарын ба агаарын бохирдлын төлбөрийн тухай хууль, -MNS4585:2025 (Агаарын чанар, Техникийн ерөнхий шаардлага) -MNS3383:1982 (Агаар мандал, Бохирдлын эх үүсвэр, нөхцөл байдал ба тодорхойлолт) -MNS5885:2008 (Агаар бохирдуулагч бодисуудын хүлээн зөвшөөрөгдсөн концентрац, Техникийн ерөнхий шаардлага)
		Уурхайн машин механизмуудын янданд шүүлтүүр тавина /TWCAT002,TWCAT0061 маркийн шүүлтүүр/	Төсөлд ашиглагдах 9 техник тоног төхөөрөмжид	1400.0	9800.0	Олборлолтод гарахын өмнө	MNS4225:2011 (Агаарын чанар, Ерөнхий танилцуулга)
		Олборлолтын ажлын үед газар шорооны ажлыг аль болохоор бага хэмжээтэй хязгаартай хийнэ	Уулын ажлын үед	-	-	Төслийн бүх үе шатанд	
		Хучилтгүй зам дээр тээвэр хийх машины хурдыг хязгаарлана	Уурхайн зам болон орон нутгийн зам	1500.0		Төслийн бүх үе шатанд	
	Машинаас гарах тоос шороог багасгах үүднээс хучилтгүй замын гадаргыг шаардлагатай хэсгүүдэд засна (олборлолтын ажлаас өмнө)	Уурхайн зам		Үйл ажиллагааны зардалд тусгана.		Төслийн бүх үе шатанд	

	тээврийн хөдөлгөөн, Тээвэрлэлтэд явж буй машинуудаас ялгарах хорт бодисуудаар орчны агаар бохирдох	Тоосжилтыг дарах зорилгоор авто зам, уурхайн карьерын мөргөцөг, шимт хөрсний овоолгын тоосжилтоос хамгаалах усалгаанд ус ашигласны төлбөр	Уурхайн зам, карьерын мөргөцөг, овоолго	Үйл ажиллагааны зардлаар		2026-2027 онд	-MNS 0017-2-3-16:1998 (хүн ам суурьшсан хэсгүүдэд) -Бензин хөдөлгүүрт MNS 5013:2003 -Дизель хөдөлгүүрт MNS 5014:2003 MNS5010-2001, “ХАБЭА. Ажлын байран дахь тоосны агуулгыг хэмжихэд тавигдах ерөнхий шаардлага”
		Дуу шуугианы хэмжилтийг жил бүр хийж байх	Уурхайн зам, баяжуулах хэсэг	ОХШХ-т тусгасан		2026-2027 онд	
Нийт мян.төг						20050.0	
Усны нөөц, чанар							
2	Гадаргын усыг авч ашигласнаар голын урсцын горим алдагдах, усны бохирдол, шатах тослох материалыг алдсанаар газрын доорх ус бохирдох, газар доорх устай холбогдон ургадаг ургамжилтад сэргөөр нөлөөлж болзошгүй.	ШТМ-ын агуулахын орчмыг хатуу хучилттай болгоно.	ШТМ-ын агуулах болон түүний орчим	1200.0	1200.0	Төлөвлөлт, олборлолтын ажлын үе шатанд	-Байгаль орчныг хамгаалах тухай хууль, Усны тухай хууль -ЗГ-ын 2009 оны 351 дүгээр тогтоолын хавсралт-Ус ашигласны төлбөрийн хувь хэмжээ
		Уурхайн олборлолтын ажлын явцад орчны тоосжилтыг бууруулахад газар доорх усны нөөцийг аль болох ашиглахаас зайлсхийж, цэвэршүүлсэн ахуйн хаягдал усыг эргүүлж ашиглана.	Лицензийн талбайд	1200.0	6000.0	Төлөвлөлт, олборлолтын ажлын үе шатанд	
Нийт мян.төг						7200.0	
Хөрс, ургамлын бүрхэвч							
3	Уурхайн ашиглалтын явцад хөрсний	Уурхайн орчны авто замд тэмдэгжүүлэх ажил хийх, олон салаа зам гаргахаас сэргийлнэ.	Төсөл хэрэгжих талбай болон түүний орчим	Үйл ажиллагааны зардалд тусгана.		Төслийн эхэнд	-Хөрс. Хөрсний химийн элементүүдийн

	бүтэц найрлагад өөрчлөлт орох, хог хаягдал тоосжилтоос бохирдол үүсгэх, хүнд даацын машин механизмууд олон салаа зам гаргаж хөрс болон ургамлыг гэмтээх, ШТМ, барилгын материалын хог хаягдал, шатахуун асгарах зэрэг болзошгүй осол аваараас үүдэн хөрсөн бүрхэвчийг бохирдуулах	Ил уурхай болон газар эвдэх бусад үйл ажиллагаануудыг эхлүүлэхээс өмнө өнгөн хөрсийг хуулан авах. Уурхайн үйл ажиллагаа эхлэхээс өмнө болон түүний явцад хуулан авсан өнгөн хөрсийг тусгайлан зассан овоолго байдлаар хадгална.	Төсөл хэрэгжих талбайд			Төлөвлөлт, олборлолтын ажлын үе шатанд	нийт хэмжээг тодорхойлох арга, -MNS 5850:2008 Хөрс бохирдуулагч бодис, элементүүдийн зөвшөөрөгдөх дээд хэмжээ
		Хог хаягдлыг тээвэрлэж зайлуулна.	Орон нутагтай хамтран гэрээгээр зайлуулна.	Хог хаягдлын менежментийн төлөвлөгөөнд тусгасан.	Тухай бүрд		
		ШТМ-ын хадгалалтад хяналт тавина.	ШТМ-ын агуулахад	2000,0	Тухай бүрд		
		Олборлолтын ажил, түүний овоолго, тээвэрлэлт нь тус талбайн хөрсний эвдрэлийг аль болох бага байлгахад чиглэх, тээврийн хэрэгслийн хөдөлгөөнийг тухайн тогтоогдсон ажлын зурваст байлгах арга хэмжээ авах	Уулын ажил		-	Төсөл хэрэгжих явцад	
Нийт мян.төг						2000.0	
Амьтны аймаг							
4	Өндөр хүчдэлийн 15 кВ-ын шугамын шонгууд нь махчин шувуудын үүрлэх төдийгүй нүүдлийн үедээ сууж амрах, идэш бологч амьтдаа алсаас ажиглах, өндрөөс ангуучлахад тохиромжтой биет мөн боловч бүтэц, хэлбэрийн тохиромжгүй	Цахилгаан дамжуулах агаарын шугамд шувууны мониторинг судалгаа гүйцэтгэх, Өндөр хүчдэлийн шугамд шувуунд аюулгүй хамгаалалт байршуулах.	Шувууд цахилгаан дамжуулах агаарын шугамд хүчдэлд цохиулж эндэх эрсдэл 90% хүртэл буурна.	Ширхэг	46,800	1 жилд нэг удаа	Амьтны аймгийн тухай хууль, Байгаль орчныг хамгаалах тухай хууль. Жич: Загвар, байрлуулах тоо зэргийг судалгааны үр дүнд тулгуурлан, мэргэжлийн шувуу судлаачидтай хамтран гүйцэтгэх

	байдал нь махчин болоод бусад шувуудын хүчдэлд цохиулж олноор эндэх шалтгаан болдог. Өндөр хүчдэлийн шугамд том биетэй нүүдлийн шувууд болон махчин шувууд хүчдэлд цохиулж болон утас мөргөж эндэх эрсдэлтэй.						
Нийт мян.төг						46800	
Хөндлөнгийн хяналт							
5	Байгаль орчны аудит	Төслийн байгаль орчныг хамгаалах үйл ажиллагаанд байгаль орчны хуваарьт аудитыг эрх бүхий мэргэжлийн байгууллагаар 2 жил тутамд нэг удаа хийлгүүлэх	Мэргэжлийн байгууллагатай гэрээлэх	Жишиг тариф 5000.0	10000	2 жилд 1 удаа	Байгаль орчин, ногоон хөгжлийн сайдын 2013 оны 04 дүгээр сарын 24-ны өдрийн А-126 дугаар тушаалын 2 дугаар хавсралт “Байгаль орчны аудит хийх ерөнхий аргачлал”
6	Газрын төлөв байдал чанарын улсын хянан баталгаа	Газрын төлөв байдал чанарын улсын хянан баталгааг 5 жил тутамд хийлгэнэ.	Мэргэжлийн байгууллагаар гүйцэтгүүлэх	4000.0	4000.0	2 жил тутамд 1 удаа	
Нийт мян.төг						14000.0	
Нийгмийн хариуцлага							
7	Боловсролыг дэмжих хөтөлбөрийг хэрэгжүүлэх	Амралтаараа ажиллах боломжийг олгож оюутнуудад олгох	Орон нутгийн иргэд	Орон нутагтай байгуулах гэрээнд тусгасан зардлаар			

8	Ажлын байр нэмэгдүүлэх хөтөлбөрийг хэрэгжүүлэх	Хүнд машин механизмын мэргэжил олгох сургалтад хамруулах ажлын байраар хангах	Орон нутгийн иргэд	Орон нутагтай байгуулах гэрээнд тусгасан зардлаар			
9	Сумын болон уурхайн нөлөөллийн бүсийн айл өрхүүдийн амьжиргааг тэтгэх	Айл өрхөд өвс өгөх	Сумын хэмжээнд	Айл өрх	120	Үйл ажиллагааны зардлаар	
Нийт зардал					93050		

II.2 ОСОЛ ЭРСДЭЛИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ

Хүснэгт №. 11 Осол эрсдэлийн төлөвлөгөө

Гол ба болзошгүй сөрөг нөлөө	Урьдчилан сэргийлэх арга хэмжээ	Арга хэмжээний цар, хэмжээ	Нэгжийн өртөг, мян.төг	Нийт зардал мян.төг	Хэрэгжүүлэх хугацаа ба давтамж	Баримтлах стандарт, аргачлал
Эрсдэлээс урьдчилан сэргийлэх арга хэмжээ						
Галын аюул, гамшиг, осол аюул	“Химийн хорт болон аюултай бодис, бүтээгдэхүүний агуулах. Ерөнхий шаардлага” MNS 6458 : 2014 стандартад заасан химийн бодисын агуулахын холбогдох бүх шаардлагыг барилгын зураг төсөл, тогтмол үйл ажиллагааны төлөвлөгөөнд тусгаж стандартыг мөрдөж ажиллах	Барилгын зураг төсөл ба үйл ажиллагааны төлөвлөгөөний хүрээнд			Үйл ажиллагааны эхний жилд	Гамшгаас хамгаалах тухай хууль, Гал гарах үед анхааруулгын самбар объектоос гарах схем зураглал, галын хорын нэгж талбайд ноогдох стандарт MNS 5566 2005
	Агуулахын байгууламжийг анхан шатны галын аюулын эсрэг хэрэгслээр холбогдох норм, дүрэм журмыг баримтлан хангах (галын хор, элс, ус нөөцлөх сав гэх мэт) галын аюулын эсрэг хэрэглэх материалыг шинэчлэн солих / Галын хорын ашиглах хугацаанаас хамаарч, анхааруулгын самбар, гал гарах үед хэрэглэх багаж хэрэгсэл., /	Объектын доторх ашигтай талбайгаас хамаарч 80м ² ихгүй талбайд тус бүр 1ш галын хор 40.0 байршуулах Эхний байдлаар 3-5 ш хор	10.0 хор + 5 иж бүрдэл	0.5	Жилд нэг удаа	
		Галын дүгнэлт, зөвшөөрөл	500.0	500.0	Үйл ажиллагааны эхний жилд	Галын аюулгүй байдлын тухай хууль
	Шаардлагатай тохиолдолд галын эсрэг төхөөрөмж нэмэлтээр суурилуулж, галын хорын тоог нэмэгдүүлэх, гэнэтийн осол аюулын үед ашиглах хамгаалах хэрэгслийг (амьсгалын баг гэх мэт) байршуулах		Гүйцэтгэлээр төсөвлөнө.			Гамшгаас хамгаалах тухай хууль
	ТМА-ын үйл ажиллагааны явцад галын аюул, гамшгийн эрсдэлийн үнэлгээг мэргэжлийн байгууллагаар гүйцэтгүүлэх	Гамшгийн эрсдэлийн үнэлгээ	Жишиг тариф 2500.0 Гэрээгээр тохиролцсон төсвөөр			Гамшгаас хамгаалах тухай хууль
	Онцгой байдлын газартай хамтарч гэнэтийн гал түймэр, гамшиг осолтой тэмцэх аргачилсан заавар зөвлөгөөг боловсруулж өөрийн ОБХТ–	Гамшгаас хамгаалах төлөвлөгөө	500.0		Ашиглалтын хугацаанд	Гамшгаас хамгаалах тухай хууль

	д (ослын байдлыг хязгаарлах төлөвлөгөө) тусгах, өөрөөр хэлбэл авах ёстой арга хэмжээний дэс дарааллыг тодорхой тусгаж, хариуцах эзэнтэй болгох				
	Гамшиг, ослын байдлыг хязгаарлах төлөвлөгөөг ажилчдад таниулж сургах ба сургалтын протокол хөтөлж баримтжуулах	Зохион байгуулах	350.0*5=1750	Жилд 1 удаа	Гамшгаас хамгаалах тухай хууль
	Ажилчдыг галын хор болон бусад хэрэгслийг ашиглаж сургах, дадлага эзэмшүүлэх зэрэг зохион байгуулалтын арга хэмжээг авах		350.0*5=1750		
Нийт			6500.0		

II.3 ХОГ ХАЯГДЛЫН МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ

Хүснэгт №. 12 Хог хаягдлын менежментийн төлөвлөгөө

д/д	Хог хаягдлын талаар хийгдэх ажлууд	Зарцуулагдах зардал мян.төг		Шалгуур үзүүлэлт
		2026 он	2027 он	
1	Ахуйн шингэн болон хатуу хог хаягдал хаях цэгээ Дэлүүн сумын засаг даргаар тогтоолгоно.	-	-	Дэлүүн сумын засаг даргын захирамж байна.
2	Ахуйн хог хаягдлаа эрх бүхий байгууллагатай гэрээ байгуулан тээвэрлүүлнэ.	Төлбөр нь уурхайн үйл ажиллагааны зардалд орсон		Гэрээ байна.
3	Хог хаягдлын төлбөрөө төлнө.	Төлбөр нь уурхайн үйл ажиллагааны зардалд орсон		Төлбөр төлсөн баримт байна.
4	Хатуу хог хаягдлын хэмжээг тогтоож Дэлүүн суманд улирал тутамд мэдээллэж байна.	-	-	Уурхайд 81 хүн ажиллах бөгөөд сард ойролцоогоор 546 кг бохир хаягдал гарна.
5	Уурхайн засварын цехээс гарах ашигласан тос маслыг эрх бүхий байгууллагад шилжүүлнэ.	Төлбөр нь уурхайн үйл ажиллагааны зардалд орсон		Хог хаягдлын журнал хөтөлж явна.
6	Шингэн хаягдал хөрс болон гүний усыг бохирдуулж байгаа эсэхийг шалгаж биологийн болон химийн шинжилгээ хийлгэнэ.	-	-	Хяналт шинжилгээний хөтөлбөрт зардал нь тусгагдсан.
7	Зуны улиралд хогийн сав болон ажилчдын амьдрах байр, гал тогоонд хортон шавжийн ариутгал халдваргүйжүүлэлт хийлгэх	400.0	400.0	Баян-Өлгий аймгийн гоц халдвартын төвөөр хийлгэх
8	Ахуйн бохир ариутгах, халдваргүйжүүлэх, задлах бодис худалдаж авах зардал	1500.0	1500.0	Зардлын задаргааг доор оруулав.
9	Аюултай хог хаягдал хадгалах, тээвэрлэх зардал	-	-	“Түмэн-эгшиг”ХХК-тай гэрээтээр
Нийт зардал мян.төг			1900.0	

II.4 ТЭР БУМ МОД, ҮНДЭСНИЙ ХӨТӨЛБӨР

Байгаль орчин, аялал жуулчлалын сайд, сангийн сайдын хамтарсан 2021 оны 07 сарын 09-ны өдрийн А/172, 116 дугаарт “Ойжуулалт, ойн аж ахуйн арга хэмжээний зардлын нормативыг шинээр болон шинэчлэн батлах тухай” хөтөлбөрийг тусгав.

Тус хөтөлбөрийн хүрээнд төслийн талбайн замын хоёр талаар ойн зурвас үүсгэх маягаар 1-р жилд 300 хайлаас, 200 улиас, 2-р жилд 400 хайлаас, 200 улиас тарина. Жич: Дээрх бүх модыг /3-4 насны/ мод тарина.

Хүснэгт №. 13 Төслийн талбайн ойжуулалтын зардал

№	Зардлын утга	Нийт зардал	Зардлын утга	Нэгж	Талбайн хэмжээ	Тоо ширхэг	Нийт ажлийн зардал
1	Навчит модны суулгацаар ойжуулах	6 000 000	Ойт хээр	га	0.5	500 ш	11,000,000
2	Навчит модны суулгацаар ойжуулсан талбайн арчилгаа	5 000 000					

II.5 ТҮҮХ, СОЁЛЫН ӨВИЙГ ХАМГААЛАХ ТӨЛӨВЛӨГӨӨ

“Оюут толгой ” нэртэй зэс-алтны орд төслийн барилга байгууламжуудыг барьж байгуулах, тэдгээрийг ашиглахад Баян-Өлгий аймгийн Дэлүүн сумын нутаг дэвсгэрт буй улсын болон орон нутгийн тусгай хамгаалалттай газруудад шууд сөрөг нөлөөлөл байхгүй. Төслийн талбайд барилга байгууламжуудыг барьж байгуулах, төслийн үйл явцад ямар нэг түүх соёлын дурсгалын шинжтэй зүйл илрүүлсэн тохиолдолд Соёлын өвийг хамгаалах тухай хуулийн 17.11-ийн дагуу холбогдох байгууллага, албан тушаалтанд нэн даруй мэдэгдэх, боломжтой бол хамгаалах арга хэмжээ авах үүрэгтэй.

II.6 ОРЧНЫ ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭНИЙ ХӨТӨЛБӨР

Орчны хяналт шинжилгээний хөтөлбөрт тус ордыг ашиглах төслийн үйл ажиллагааны явцад байгаль орчин, хүний амьдрах орчинд хэрхэн нөлөөлж байгаа, үзүүлж буй нөлөөлөл нь зөвшөөрөгдөх хязгаарт байгаа эсэхийг хянах үзүүлэлтүүдийг тодорхойлж хэмжих, шинжлэх арга стандарт, хяналт хийх байршил, давтамж зэргийг бүхэлд нь тусгасан болно.

Байгаль орчны хяналт шинжилгээний хөтөлбөрийг хэрэгжүүлэх, батлагдсан арга зүйг баримтлан стандартчилагдсан багаж, хэрэгслээр дээж, шинжилгээг мэргэжлийн байгууллагаар хийлгэх болон үр дүнг хянах ажлыг “Орчлон-Орд” ХХК-ийн байгаль орчны асуудал хариуцсан ажилтнууд удирдана.

Байгаль орчны хяналт шинжилгээний хөтөлбөрийн хэрэгжилт, үр дүн, түүнд хийсэн дүгнэлт зэргийг жил бүрийн 11 сард багтааж сум, аймгийн төрийн захиргааны төв байгууллагуудад хүргүүлэн хянуулж, дараа оны байгаль орчны хяналт шинжилгээний хөтөлбөрийг батлуулах хэрэгтэй.

Орчны хяналт шинжилгээний хөтөлбөрийг хэрэгжүүлэгч болон түүний хэрэгжилтийг хянах субъектүүд ажил, үүрэг: Байгаль орчны мэргэжилтэн дараах ажлыг гардан зохион байгуулна.

- Төсөл хэрэгжүүлэгчийн жилийн төсөвт хөтөлбөр хэрэгжүүлэгчтэй холбогдсон зардлыг тусган батлуулсан байх,
- Төслийн талбайн ойр орчмын цэгүүдээс дээжийг тогтоосон хугацаанд нь мэргэжлийн байгууллагуудаар авуулж, лабораторийн шинжилгээ хийлгүүлэх,
- Орчны хяналт шинжилгээний ажлыг байгаль орчны шинжилгээний төв лаборатори зэрэг мэргэжлийн байгууллага, мэргэжилтэн гүйцэтгэх ба түүнд зориулалтын тоног төхөөрөмж, багаж хэрэгслийг ашиглах,
- Шинжилгээний үр дүнг суурь үзүүлэлттэй жишин үзэж, дүгнэлт гаргуулах шаардлагатай, шийдвэрийн төсөл боловсруулах
- ИТХ, түүний тэргүүлэгчдэд хөтөлбөрийн хэрэгжилтийг тайлагнуулах, шаардлагатай шийдвэр гаргуулах арга хэмжээ авуулж, гүйцэтгэлийг хянах

Төсөл хэрэгжүүлэгч дараах асуудлыг хариуцна.

- Орчны хяналт шинжилгээний хөтөлбөрийг хэрэгжүүлэхтэй холбогдсон зардлыг жил бүрийн төсөвт тусган саадгүй төлөх,
- Хөтөлбөр хэрэгжүүлэхтэй холбогдуулж тухайн орон нутгийн Иргэдийн нийтийн Хурал, түүний тэргүүлэгчдийн гаргасан шийдвэр, арга хэмжээг хэрэгжүүлэх,
- Хяналт шинжилгээний үр дүнг сар, улирал, хагас жил, жилээр нэгтгэн гаргаж, Баян-Өлгий аймгийн Дэлүүн сумын иргэдийн нийтийн хурлын тэргүүлэгчид ба БОАЖЯ-нд тайлагнаж байх,
- Хяналт шинжилгээний үр дүнгийн бүртгэл, тайлангийн хүснэгтийн загварыг Баян-Өлгий аймгийн Дэлүүн сумын Засаг даргын тамгын газар болон хяналт шинжилгээ хийсэн мэргэжлийн байгууллагаас авах.

Иргэдийн төлөөлөгчдийн хурал, түүний тэргүүлэгчид дараах асуудлыг хариуцна.

- Орчны хяналт шинжилгээний хөтөлбөрийн хэрэгжилтэд хяналт тавьж, эрчимжүүлж, заавал хэрэгжүүлэх арга хэмжээ авах,
- Төслийн үйл ажиллагааны улмаас байгаль орчны төлөв байдалд нөлөөлж буй асуудлаар иргэдийн санал хүсэлтийг авч судалгаа явуулах,
- Шаардлагатай асуудлаар зөв шийдвэр гаргах, арга хэмжээ авах


Эдийн засаг талаасаа гол үзүүлэлтүүд нь борлуулалтын орлого, бүтээгдэхүүний өртөг, татвар төлбөрүүд, төслөөс олох ашиг юм. Борлуулалтын орлогын хэмжээ дэлхийн зах зээлээс хамаарч хувьсан өөрчлөгдөх бол бүтээгдэхүүний өртөг уурхайн төлөвлөлт, тоног төхөөрөмжийн сонголт, дэвшилтэт технологи, тухайн компанийн менежментээс хамааран хэлбэлзэлтэй байна. Бүтээгдэхүүнийхээ өртгийг ямагт бууруулж ажиллах нь эдийн засгийн үр өгөөжийг нэмэгдүүлж ирээдүйд бий болох эрсдэлээс хамгаална.

Хүснэгт №. 14 Орчны шинжилгээний хөтөлбөр

Хяналт шинжилгээ хийх үзүүлэлтүүд	Байршил	Хугацаа ба давтамж	Нэгжийн өртөг, мян.төг	Нийт зардал төг/жил	Баримтлах стандарт ба арга аргачлал
Усан орчин					
Усны рН, цахилгаан дамжуулах чадвар нүүрстөрөгчийн исэл CO ₃ , хүчил HCO ₃ , кальци Ca, хлор Cl, кали K, магни Mg, сод Na, хүхэр S, хүнцэл As, бор B, бари Ba, кадми Cd, кобальт Co, хром Cr, зэс Cu, төмөр Fe, мөнгөн ус Hg, манган Mn, молибден Mo, никель Ni, хар тугалга Pb, селени Se, силиконSi, ванади V, цинк Zn, хөнгөн цагаан Al, мөнгө Ag, Хими бактериологийн бүрэн шинжилгээ.	-Унд ахуйн хэрэглээнд ашиглах худагт	Жилд 4 удаа мониторингийн цэгүүдээс дээжлэлт хийж лабораторийн шинжилгээнд өгнө.	Усны ерөнхий химийн шинжилгээ 25.0 мян.төг, Усны 23 элемент хүнд металлын шинжилгээ 60.0 мян.төг, Хими бактериологийн бүрэн шинжилгээний үнэ 120.0 мян.төг 1 жилд 4 удаа буюу нийт 820.0 мян.төг	820*5жил= 4100.0 мян.төг	-MNS0900:2005 Ундны ус-Ундны усны хяналт шинжилгээ -Усны чанар хаягдал бохир ус MNS 4943:2000
Хөрсний төлөв байдал, бохирдолт					
Нефть, нефтийн бүтээгдэхүүн, Хар тугалга, Азот, Фосфор, Усан мандал, Кальци, Магни, Кали, Магни, Хлор, Сульфат, Карбонат, Гидрокарбонат, Ариун цэврийн тоо, Коли- титр, Перфрингес-титр	Төслийн талбайд	Жилд 4 удаа мониторингийн цэгүүдээс дээжлэлт хийж лабораторийн шинжилгээнд өгнө.	Хөрсний механик бүрэлдэхүүн, ялзмаг 40.0 мян.төг Хөрсний хүнд металл шинжилгээний үнэ 60.0 мян.төг 1 жилд 4 удаа 400.0 мян.төг	400.0мян.төг *5 2 жилд = 2000.0 мян.төг	-MNS 5850:2008, Хөрсний чанар. Хөрс бохирдуулагч бодис, элементүүдийн зөвшөөрөгдөх дээд хэмжээ
Агаарын чанар					
-Тоосжилт (PM ₁₀ , PSM, PM ₂₅) - Температур, Агаарын урсгал, Чийгшил, Нүүрстөрөгчийн исэл, Хүхэрт устөрөгч, Метан, Азотын давхар исэл, Аммиак г.м	Төслийн талбайд	Жил бүр 2 удаа. Шаардлагатай тохиолдолд тухай бүрд нь.	24 цагийн хэмжилт хийж (O ₂ , SO ₂ , NO ₂ , CO , цаг агаарын үзүүлэлт)-ийу	500.0 төг*2*5 жилд= 5000.0 сая.төг	-ISO 9001:2000 MNS0017.2.5.12:88 Хүхэрлэг хий-SO ₂ шинжлэх ТХМ буюу аэрозалины арга

			хамт тооцоход 500.0 мян.төг Байгаль орчин аялал жуулчлалын сайдын 2011 оны 10 сарын 10-ны өдрийн А-342 дугаар тушаалын хавсралтаар үнийг тооцов. 1 жилд 1000.0		-MNS0017.2.5.11-88 Азотын давхар исэл
Ургамал					
-Хяналт шинжилгээ хийх талбайн хүрээ, хяналт үнэлгээгээр тодорхойлох үр дүнг тухай бүрд нь тодорхойлно.	Төслийн талбайд	жилд 1 удаа	Мэргэжлийн шинжээч хөлслөх, 1500.0 мян. төг	1500 *5 жил = 7500.0 сая.төг	-Тухайн төслийн талбай болон орчных нь байгалийн унаган төрхөөрөө байгаа экосистемтэй харьцуулах аргаар тодорхойлох
Амьтан					
Шувууны судалгаа					
Өвөлжиж буй шувуудын зүйлийн бүрдэл, тоо толгой			3-р сард		
Хаврын нүүдлийн шувуудын зүйлийн бүрдэл, тоо толгой			4- сарын сүүл, 5, 6-р сарын эх		
Үржиж буй шувуудын зүйлийн бүрдэл, тоо толгой			5, 6 сар		
Намрын нүүдлийн шувуудын зүйлийн бүрдэл, тоо толгой			8-р сарын сүүл 9-р сарын эх		
Хоёр нутагтан, мөлхөгчид					
Нөхөн сэргээсэн талбайн хоёр нутагтан, мөлхөгчдийн зүйлийн бүрдэл, популяцын хэмжээ			6,7,8-р сард		
Байгалийн талбай дахь хоёр нутагтан, мөлхөгчдийн зүйлийн бүрдэл, популяцын хэмжээ			6,7,8-р сард		
Хөхтний судалгаа					
Өвөлжиж буй хөхтний зүйлийн бүрдэл, тоо толгой			3-р сард		
Үржиж буй хөхтний зүйлийн бүрдэл, тоо толгой			7-р сард		
Хөхтний популяцын өөрчлөлт			8-р сард		
Жилд 1 удаа Мэргэжлийн шинжээч хөлслөх, 2000.0 мян.төг, 2000 *5 жил = 10000.0 сая.төг					

II.7 Төслийн талбайн мониторингийн ажлууд



Зураг №. 9 Мониторингийн цэгүүд

Хүснэгт №. 15 Мониторингийн цэгийн солбицол

№	Нэр	Уртраг			Өргөрөг		
		Градус	Минут	Секунд	Градус	Минут	Секунд
1	Гүний худаг 1	90	45	16.75	47	29	20.83
2	Гүний худаг 2	90	44	40.93	47	29	50.41
3	Гүний худаг 3	90	44	40.82	47	29	42.83
4	Агаарын хэмжилт 1	90	45	7.92	47	29	45.05
5	Агаарын хэмжилт 2	90	45	10.49	47	29	24.58
6	Агаарын хэмжилт 3	90	45	4.5	47	30	18.17
7	Ургамлын мониторинг 1	90	45	0.96	47	29	46.4
8	Ургамлын мониторинг 2	90	45	11.88	47	29	8.09
9	Ургамлын мониторинг хяналт	90	44	28.78	47	30	55.7
10	Хөрс-1 хяналт	90	45	20.87	47	30	43.19
11	Хөрсний мониторинг	90	44	58.07	47	29	49.13
12	Баяжуулах үйлдвэр	90	45	8	47	29	52
13	Химийн бодисын агуулах	90	44	17	47	31	22
14	Уурхайн кэмп	90	45	14	47	29	25

Төслийн талбайн эхний жилийн мониторингийн цэгүүдийг дээрх зурагт дүрслэн үзүүлсэн болно. Үүнд:

- *Усны шинжилгээ хийх мониторинг:* Төслийн талбайн ойролцоох Үертийн голоос тухайн төсөл эхлэхээс өмнө нэг дээж, төсөл хэрэгжиж байх хугацаанд нэг дээж, төслийн хаалтын үед нэг дээж гээд нийт 3 дээжийг шинжлүүлнэ.
- *Хөрсний шинжилгээ хийх мониторинг:* Төслийн талбайн хэмжээнд нийт 3 хөрсний дээжийг авах ба эхний хөрсний мониторингийн цэгийг ажилчдын

тосгоны ойролцоо, удаах мониторингийн цэгийг баяжуулах хэсэгт, хамгийн сүүлийн цэгийг төслийн талбай доторх аван шинжлүүлнэ.

- *Агаарын шинжилгээ хийх мониторинг:* Төслийн талбайн хэмжээнд нийт 3 агаарын дээж авах ба эхний агаарын мониторингийн цэгийг ажилчдын тосгоны ойролцоо, удаах мониторингийн цэгийг баяжуулах хэсгийн ойролцоо, хамгийн сүүлийн цэгийг төслийн талбай доторх хэсэгт аван шинжлүүлнэ.

Төслийн талбайн хоёрдох жилийн мониторингийн цэгүүдийг дээрх зурагт дүрслэн үзүүлсэн болно. Үүнд:

- *Усны шинжилгээ хийх мониторинг:*
- Үертийн голоос тухайн төсөл эхлэхээс өмнө нэг дээж, төсөл хэрэгжиж байх хугацаанд нэг дээж, төслийн хаалтын үед нэг дээж гээд нийт 3 дээжийг шинжлүүлнэ.
- *Хөрсний шинжилгээ хийх мониторинг:* Төслийн талбайн хэмжээнд нийт 3 хөрсний дээжийг авах ба эхний хөрсний мониторингийн цэгийг ажилчдын тосгоны ойролцоо, удаах мониторингийн цэгийг баяжуулах хэсэгт, хамгийн сүүлийн цэгийг төслийн талбай доторх аван шинжлүүлнэ.
- *Агаарын шинжилгээ хийх мониторинг:* Төслийн талбайн хэмжээнд нийт 3 агаарын дээж авах ба эхний агаарын мониторингийн цэгийг ажилчдын тосгоны ойролцоо, удаах мониторингийн цэгийг баяжуулах хэсгийн ойролцоо, хамгийн сүүлийн цэгийг төслийн талбай доторх хэсэгт аван шинжлүүлнэ.

Төслийн талбайн гуравдах жилийн мониторингийн цэгүүдийг дээрх зурагт дүрслэн үзүүлсэн болно. Үүнд:

- *Усны шинжилгээ хийх мониторинг:* Үертийн голын уснаас тухайн төсөл эхлэхээс өмнө нэг дээж, төсөл хэрэгжиж байх хугацаанд нэг дээж, төслийн хаалтын үед нэг дээж гээд нийт 3 дээжийг шинжлүүлнэ.
- *Хөрсний шинжилгээ хийх мониторинг:* Төслийн талбайн хэмжээнд нийт 3 хөрсний дээжийг авах ба эхний хөрсний мониторингийн цэгийг ажилчдын тосгоны ойролцоо, удаах мониторингийн цэгийг баяжуулах хэсэгт, хамгийн сүүлийн цэгийг төслийн талбай доторх аван шинжлүүлнэ.

Агаарын шинжилгээ хийх мониторинг: Төслийн талбайн хэмжээнд нийт 3 агаарын дээж авах ба эхний агаарын мониторингийн цэгийг ажилчдын тосгоны ойролцоо, удаах мониторингийн цэгийг баяжуулах хэсгийн ойролцоо, хамгийн сүүлийн цэгийг төслийн талбай доторх хэсэгт аван шинжлүүлнэ.

II.8 ТУХАЙН ЖИЛИЙН БОМТ ХЭРЭГЖҮҮЛЭХ УДИРДЛАГА ЗОХИОН БАЙГУУЛАЛТ

Хүснэгт №. 16 Тухайн жилийн БОМТ хэрэгжүүлэх удирдлага зохион байгуулалтын зардал

№	Арга хэмжээ	Хугацаа	Давтамж
II-1	Байгууллагын дээд удирдлагын зүгээс тогтмол хугацаанд хийх хяналт шалгалтын үйл ажиллагаа, байгаль орчны бодлогын хэрэгжилт, гүйцэтгэлийн үзүүлэлт, үр дүнг тайлагнах (ISO 14001, 2004).	2026	Байнгын
II-2	Байгаль орчны бодлого, зорилго, зорилт, хууль эрхзүйн болон бусад шаардлагуудын дагуу үйл явцыг хянаж хэмжих ба үр дүнг тайлагнах	2026	Жил бүр
II-3	Соёлын өвийг хамгаалах тухай МУ-ын хуулийн дагуу газрын хэвлийг ашиглах явцад түүх, соёлын дүрсгалт зүйл илэрвэл уурхай ажлаа зогсоож энэ тухай дүүргийн Засаг дарга, цагдаагийн болон уг асуудлыг эрхэлсэн эрдэм шинжилгээний байгууллагад нэн даруй мэдэгдэх	Үйл ажиллагааны турш	Жил бүр
II-4	Орон нутгийн удирдлага, бизнес, малчид, уул уурхайн компанийн хооронд харилцан ашигтай бизнесийн харилцаанд суурилсан түншлэл, хамтын ажиллагааг хөгжүүлэх;	2026	Жил бүр
II-5	Байгаль хамгаалах, нөхөн сэргээлтийн явцын талаар орон нутгийн удирдлага болон ард иргэдтэй уулзалт зохион байгуулж, тайлагнах.	2026	Жил бүр
II-6	Төслөөс үүсэж болзошгүй нөлөөллийг хамгийн бага байлгах буюу нөлөөлөлгүй байлгах үүднээс соёлын өвийг хамгаалах төлөвлөгөө боловсруулах;	2026	-
II-7	Төслийн гүйцэтгэлийг хянаж, шалгах ба эдийн засгийн алдагдал болон бусад мэдээллийг оролцогч талууд болон орон нутгийн удирдлагуудад мэдээлж байх;	2026	Жил бүр
II-8	Төслийн зүгээс байгаль орчин, нийгэм эдийн засгийн зохистой үзүүлэлтийг хангах, төслийн ажилчид ба орон нутгийн иргэдээс гомдол, санал гарсан тохиолдолд цаг алдалгүй санал гомдлыг нь барагдуулах зорилгоор менежментийн төлөвлөгөөг тогтвортой хэрэгжүүлэх;	2026	-
II-9	Компанийн зүгээс гэрээт байгууллагуудад тавих байгаль орчны хяналтыг баталгаажуулж, сөрөг нөлөөллөөс сэргийлэх, хамгаалах, гал түймэр, ослын үед дагаж мөрдөх журмын талаар гэрээнд нарийвчлан тусгах, тэдний үйл ажиллагааны улмаас байгаль орчинд учирч болзошгүй нөлөөллийн үнэлгээ хийлгэх шаардлагыг гэрээнд тусгах	2026	Тухай бүрт нь

Тухайн жилийн байгаль орчны менежментийн төлөвлөгөөний хэрэгжилтийг нөлөөлөлд өртөгч оршин суугчид, оролцогч талуудад тайлагнах хуваарь:

“Орчлон-Орд” ХХК нь Оюут толгой зэс-алтны хүдрийн ордыг ашиглах төслийн байгаль орчин, хүний эрүүл мэндэд аюул учруулж болзошгүй мэдээлэл оролцогч талуудад нээлттэй байх гэсэн зарчмыг мөрдлөг болгон ажиллахаар төлөвлөж байгаа бөгөөд нөлөөлөлд шууд ба шууд бус хэлбэрээр өртсөн болон өртөж болзошгүй тухайн төсөл хэрэгжиж буй нутгийн иргэд, орон нутгийн болон холбогдох бусад байгууллагын төлөөлөл багтсан оролцогч талуудад төслийн үйл ажиллагаа, БОМТ, түүний биелэлтийг тайлагнах үүргээ хэрэгжүүлэх зорилготой дараах арга хэмжээг төлөвлөсөн.

Хүснэгт №. 17 БОМТ-г тайлагнах хуваарь

Хугацаа	Нөлөөлөлд өртөгч оршин суугчдад танилцуулах ажил	Зардал	Зохион байгуулах хүний албан тушаал
2024.11.01	Баян-Өлгий аймгийн засаг дарга, ИНХ-ийн төлөөлөгчид, Дэлүүн сумын ЗДТГ-ын мэргэжилтэнгүүдэд танилцуулж санал авах	ЗДТГ-ийн хурлын танхимд төлөвлөгөөг танилцуулна. Компаний дотоод зардлаар	Уурхайн дарга болон компанийн захирал
	Нийт зардал	-	